

ЭРДЭНЭ ШАНЗУДБА БЭЭЖИНД ШИНЭЛЭХҮЙН ЖАСААНД ЯВСАН НЭГЭН ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Урангуя
Д.Цэнгэл**

Товч утга: 1906 онд Эрдэнэ Шанзудба Бадамдорж Бээжинд Түнли номын уншлаганд оролцсон тухайд замын тэмдэглэл бичиж үлдээсэн нь өдгөө Архивт хадгалагдаж буйг судлаач нарт зориулан уйгаржин монголоос кирилл үсэгнээ буулган танилцуулж байна.

Түлхүүр үг: Жэвзундамба хутагт, Эрдэнэ шанзудба, Хамба номун хан, Манж Чин улс, Шинэлэхийн жисаа, Хүрээ сайд.

Манж нар 1644 онд Хятадыг эзлэн аваад улмаар монголчуудыг өөрийн арга мэдэлд оруулхын тулд Халх дахь шашны хүч нөлөөг ашигласан юм. Эл үед бурханы шашин олон монголчуудын оюун санааг бүрэн эзэмдсэн байлаа.

1691 онд Халх Монгол Манжийн албат болсон тэр үеэс Энхамгалан хаан анхдугаар төрлийн Жэвзундамба хутагт Занабазарыг 10 жилийн турш өөрийн дэргэд байлгаж, түүгээр дамжуулан Халхын сүм хийдийг гартаа атгах ба шашин, сүм хийдээр дамжуулан манжийн бодлогыг хэрэгжүүлэх санаатай байжээ.¹

Тухайлбал, Энх-Амгалан хаан, “Монголчууд аймаг бүлэг олонтой агаад тун эрэлхэг хүчирхэг. Би эелдэг, энэрэнгүй дүрээр тэднийг номхотгон хүмүүжүүлж, улсын сүр хүчээр хүлээслэнэ. Үүний хамт энэрэл хайр хүртээж, сэтгэлийг нь олсны дээр аажмаар тэднийг оруулж авна. Би тэдний гуйлтыг үндэслэж зарлиг буулгаж, нэг сүм байгуулахын хамт 48 засаг, хошуу, Халх засаг, Ойрад засаг тус бүрээс нэг хуврага татаж, нийт 120 хүнийг энэ сүмд суулгана. Бас бурханы шашныг нэгтгэсэнтэй адилаар алс холын газраас цөм хүн томилон бүгдээрээ тус сүмд цугларан хамтаараа шашны дүрмийг журамлана. Энэ нь аливаа гол мөрөн цөм далайд цутгахтай адил” гэж байжээ. Найралт төв хаан 1723 онд Өндөр гэгээн Занабазарт “Шашныг мандуулагч” цол алтан тамга, алтан навчит өргөмжлөл хүртээн, түүний шавь нарыг захирсан Эрдэнэ шанзудба ба Их Хүрээний хамба номун хаанд тамга олгожээ.

Монгол нь Манжийн албат болсны хувиар Манжийн хааныг өөрсдийн эзэн хэмээн үзэх болжээ. Дайчин улсын Бүгд хуулийн 80 дугаар дэвтэрт: “Аливаа бараалхахаар ирэх нь Халх, Дөрвөдийг жишээ зохиож хан, ван, бэйл, бэйс, гүн, тэргүүн зэрэг тайж нарыг хуваан оноож гүйцэтгэмүй. Жибзундамба хутагт албан барихаар ирэх нь есөн цагаан барихаар ирнэ. Цагаан тэмээ нэг, саарал морь найм.

¹ Буянчуулган Б., Дэндэв Л. Манжаас Монголыг эзэрэхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн. Худам монгол бичгээс кирилл бичигт буулгасан Ж.Урангуя, З.Энхтайван. УБ.,2010, т.48

Халхын Түшээт хан, Сэцэн хан дагалдана. Жил бүр нэг удаа хүн зарж барихаар ирнэ. Халх, Дөрвөдийн олон ван, гүн, тайж нар бараалхахаар ирэхэд тэмээ, морь, зумалсан хонь барина. Тогтоосон тоо үгүй. Олон сүмийн лам нар болвоос алба барихаар ирэхэд тогтоосон юм үгүй. Мөн тогтоосон хугацаа үгүй. Хэрэв ирэх чимээ үгүй болвоос харьяат газар орны түшмэдэд тушааж уламжлан бариулмой хэмээжээ.² Энэхүү баримтаас үзвээс лам нарын төлөөлөгчид Бээжинд очиж эзэн хаанд бараалхахыг тогтоосон зүйлгүй хэмээн хуулиндаа заасан боловч мөн тэнд ирэх ёстой гэдгийг дашрамд сануулжээ.

Архивын эх сурвалжаас үзвээс, “Тэнгэрийн тэтгэсний 50 дугаар он (1785) өвлийн тэргүүн сарын хорин хоёронд зарлиг буулгасан нь Юндэндорж нарын газраас³ Ачит номун хан Дүнхэр хутагт Лувсандовданванчуг энэ жил Бээжинд бараалхахаар илгээхийг гуйн айлтгажээ. Хүрээнд гурван ихээхэн ламын дотор Мэргэн хамба номун хан бие түүхий тул Бээжинд үл орохоос гадна үлдсэн Лувсандовданванчуг Дамчойравжаа хоёр хүнийг хэрэв жил бүр ээлжээр жасаалан бараалхар ирүүлбээс даруй нэгэн жил алгасуулаад нэгэн удаа ирэхэд хүрмүй. Тэдний хүчин тэсэхгүйг болзошгүй. Ачит номун хан энэ жил ирэхийг хэлж хойд жил бараалхахаар иртүгэй. Үүнээс хойш тэдний 2 хүнийг жил алгасуулан жич ээлжилж нэгийг ирэх явдлыг Хүрээ сайд⁴ Юндэндорж нарт тушаагаад дагаж явтугай хэмээсэн байна. Дээд зарлигийг хичээнгүйлэн дагаж Хүрээний Хамба номун хан, Эрдэнэ шанзудба 2 хүн ээлжлэн жасаалсаар иржээ. Ер олон хувилгаан лам нарын адил жасаанд оруулсангүй. Хэрвээ жасаалах жилд биед үнэхээр шалтгаан саатал тохиолдвоос учрыг гаргаж Хүрээний манж болон монгол сайдуудад мэдүүлж уламжлан айлтгаад, чөлөө олгосон удаа буй. Хамба номун хан⁵, Эрдэнэ шанзудба⁶ нар ээлжлэн Нийслэл хотонд орж Тэнгэрийн гэгээнээ бараалхан мөргөж Түнли⁷ ном уншихуйд тус тусдаа да лам арван тавыг авч Богд эзний түмэн амгалангийн эрэхүйд Хамба номун хан Аюуш бурхан нэг суурь, хадаг нэг, морь нэг ес, Эрдэнэ шанзудба Аюуш бурхан нэг, хадаг нэг, булга нэг ес, төвд чэсэм хоёр ес, морь хоёр есийг барьмуй”⁸ хэмээсэн байна. Үүний

² Буянчуулган Б. Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдэхүүн. УБ., 1936, т.23.

³ Хүрээний монгол сайд.

⁴ Тэнгэрийг тэтгэсний 42 дугаар онд(1777) зарлигаар Хүрээнд сууж хэрэг шийтгэх сайд монгол, манж нигжээдийг байгуулж, Богдыг харгалзах хиа сайдыг татаж, шинэ сайдын газар Түшээт хан, Сэцэн хан, Их Шавь гурван газрын хэргийг эрхлэн шийтгүүлснээс гадна Орос лугаа харилцах хэргийг эрхлэн шийтгүүлжээ.

⁵ Жэвзүндамба хутагтын Их Хүрээний ном унших, лам шавь нарыг захирах хүний албан тушаал. Анх Найралт Төвийн тэргүүн онд Эрдэнэ шанзудбын яамын байгуулахад хамт бий болгосон. Их Хүрээний Хамба номун хан нь Шадзудбатай адил эрих хэмжээтэй, Жавзундамба хутагтын шашны хэргийг тэргүүлэн гүйцэтгэх бөгөөд Жавзундамба хутагтын заавар зөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулна. Мөн дэд хамба гэж байна. Энэ нь Хамба номун ханы туслах бөгөөд түүний эзгүйд Хамба номун ханы тамгын хэргийг хамаарч үйл ажиллагааг орлон гүйцэтгэнэ.

⁶ Эрдэнэ Шанзудбын яамыг “Их шавийн яам” гэж бас нэрлэдэг. Их шавийн асуудлыг эрхлүүлэх зорилгоор 1723 онд манжийн хааны зарлигаар байгуулж тамга олгожээ. Энэхүү яамыг байгуулахын өмнө Богдын шавь нарыг Түшээт хан эрхлэн захирч байжээ. Эрдэнэ Шанзудбын яам нь аймгийн чуулган даргын эрих мэдэлтэй адил байсан бөгөөд 1822 оноос Манжийн хааны зарлигаар эрх мэдлийг нь улам өргөтгөсөн байна

⁷ Манж хааны насан хутгийн төлөө уншдаг ном.

⁸ УНС. Гар бичмэлийн сан. “Дээрэхийн уг эх” Гутгаар дэвтэр. т.89

дагуу Монголын шашны тэргүүн дээд албан тушаалтнууд Бээжинд очиж Манж Чин улсын хаанд хүрдэгтэл үзүүлж, Түнли ном уншлаганд оролцох болжээ. Тэр үеэр Манжийн хаан хүрэлцэн очигчдод бэлэг шан олгож байсан нь Манжийн төрөөс Монголын шашныг дэмжиж байсны нэгэн илрэл бөгөөд нөгөө талаар шашныхнаар дамжуулан Монголыг эрэхшээлдээ байлгаж байх нэгэн арга ухаан байжээ.

Гэвч Бээжинд бараалхахаар очигсод олширч байсны улмаас хожим нь Төр гэрэлтийн арван нэгдүгээр оноос хатуу журамлан, тогтоосон тооны хэмжээнд байхыг шаардаж байжээ. Мөн түүнчлэн Хүрээн дэх манж, монгол сайдын газраас тусгайлан бичиг үйлдэн явуулах явдлыг тухайд Их Шавийн⁹ Эрдэнэ Шанзудбын яамны данс хараанд” ... сайдууд танай газраас тушаасан бичгийн дотор Их Журганаас Жавзандамба хутагтын шанзудба үүнээс хойш шинэлэхийн жасаанд тохиолдвоос Нийслэл хотод ирэх Да лам арван таваас илүү авахыг хэрэгсэхгүй. Хэрвээ Да лам нарыг авч Дээдийн амгаланг эрсүгэй хэмээвээс ирсүгэй харъяат захирах сайдуудын газраас тамга дарсан бичиг гаргаж өртөгн тодорхойлон мэдүүлэн ирүүлсүгэй, хэрэхэвчээр зоргоор авбаас болохгүй хэмээн хүргэж ирсэн явдлыг хянан байцаан үзэж дагаж явуулъя хэмээн тушаасныг дагах тухайд үүнээс хойш Эрдэнэ шанзудбын бие шинэлэхийн жасаа тохиолдвоос хуучин ёсоор Да лам арван тавыг авч Дээдийн амгаланг эрх явдлыг уг тушаасан ёсоор тамга дарсан бичиг авч одох явдлыг урьд нэгэнт өргөн мэдүүлснийг дансанд тэмдэглэжүү”¹⁰ хэмээжээ. Энэхүү баримтанд дурьдсан зүйлийг нягтлан үзэхүйд дээр дурьдсан. Түнлийн уншлаганд оролцохоор Хамба номун хан, Шанзудба нар Бээжинд жасаалан очихоос гадна мөн тэд Шинэлэхийн жасаанд оролцож байсан бөгөөд Түнли жасаанд явахын нэгэн адил бэлэг сэлт манжийн хаанд өргөн барьж байжээ.

Доор бид нэгэн баримтыг толилуулж байна. Энэ нь 1906 онд Эрдэнэ Шанзудба Бадамдорж¹¹ Шинэлэхийн жасаанд Бээжин явсан замын тэмдэглэл юм. Энэхүү баримт өдгөө Монгод улсын Түүхийн төв Архивын Их Шавийн Эрдэнэ шанзудбын яамны нэгдүгээр дансны хадгаламжийн нэгж 1259-д, хатуу цаасан хавтастай, нүүрэн талын баруун дээд өнцөгт 1-34 хүртэл хөх өнгийн бэхээр ромбо тоогоор дугаарласан бүгд 34 нүүр хуудастай баримт хадгалагдаж байна. Тус сурвалжаас үзэхүл, Их Шавийн шанзудба Бадамдорж 1906 оны 12 дугар сарын 11-нд Их Хүрээнээс Бээжин орж Шинэ жилийн баяр ёслолын үеэр Манж Чин улсын эзэн хаанд бараалхахаар мордохдоо арван зургуул явжээ. Үүнд, Шанзудба ноёнтон өөрөө мөн түүний зайсан хөтөл, эмч, бичээч, аягач, хаалгач нар тус бүр хөтөл нартайгаа мөн ачигч, шадар бараа бологч, бичээчийн хоёр хүү, шадар бараа бологчийн хүү зэрэг аж. Энэ удаад шанзудбаг дагалдан 15 да лам яваагүй байна.

⁹ Богдын шавийг бусад хутагтуудын шавиас ялгаж “Их шавь” хэмээн нэрлэдэг.

¹⁰ УТА М 85, Д 3, хн-495, нугалбар 14

¹¹ Бадаргуулт төрийн хорин есдүгээр (1903) оноос Хэвт ёсны хоёрдугаар он (1910) Их шавийн шанзудба, Олноо өргөгдсөний тэргүүн (1911) онд дахин Эрдэнэ шанзудбын тушаалд томилогдож улмаар Олноо өргөгдсөний 2-5 дугаар онд Монгол улсын Шашин төрд туслах яамны сайдаар ажиллаж байгаад Олноо өргөгдсөний тавдугаар (1915) оноос Дотоод яамны тэргүүн сайд болсон амуй.

Ингээд Эрдэнэ шанзудба Шинэлэхүйн жасаанд морилхоор адхийн өмнө VIII Богд Жэвзүндамба хутагтад мөргөөд, их цай хүртээд морин цагт, Их Хүрэнээс морилохуй дор яамны үүдэнд нь сангийн олон албаны хүмүүн нар яамны үүдэнд ёслон зогсчээ. Тэндээс ордонд морилж, Очирдарь шүтээнд ёслоод, шанзудбын тамгыг хамааруулж, Шаравпэлжээлин сүм дор дээр бараалхав. Дараагаар цайны асар дор их цай хүртэж, олон хувраг нартай амгалангийн хадаг сольж, ихэс лугаа ёсолж мөн Эрдэнэсэцэн ноёнд, Вангай хоёр аймгаас байгуулсан асар дор цай барьж ёслоод, Маймаа хотын баруун этгээд Туул голын хөвөөнд хоноглоход нь Сангаас дөрвөн хүн гарган өгчээ.

Шанзудба тэргүүтэй хүмүүс Шинэлэхийн жасаанд Бээжин явах болон ирэх замдаа нийтдээ бараг 3 сар болжээ. Төлөөлөгчид 13 хоног Ар Монголын газар нутгаар аялан дараа нь өмнөт Монголын нутгаар 6 хоног, нийт 18 хоног хөдөө хээр хоноглосоор яваад Чуулалт хаалганаас Бээжин хүртэлх замд түнш худалдаачдын¹² пүүсүүдэд нилээд тухлан 10 хоног буудалсаар Бээжинд хүрэлцэн очиж Халх хүрээнд буудалж, улмаар Монгол Журганд албаны бичиг өргөжээ. Тэдгээрийн буудлан явсан газрын нэрийг харахад өнөөгийн Монгол, Хятадыг холбосон гол замын дагуух буудал суурингууд байна.

Шинэлэхийн жасаанд хүрэлцэн ирсэн Дотоод чуулганы¹³, Хөх хот зэрэг газрын хутагт, Номун хан, хувилгаан нарын хамт Журганы ноёдын амрыг эрж бараалхаад, хуулиар тогтоон өгсөн бэлэг сэлтээ хүлээлгэн өгчээ. Арван таван да ламын барих ёстой 15 морьдыг ч хүлээлгэн өгчээ.

Жасаалагчид шинэ он гарахаас сарын өмнө тийнхүү Бээжинд хүрэлцэн очжээ. Шинэлэхийн жасаанд хүрэлцэн очсон хүмүүст Монгол Журганаас хуулийн дагуу хоногийн хүнс буулгахад шанзудбагийн өдрийн хүнсэнд 2 лан 5 цэн, 15 да лам нарт өдөр бүр хүн тутамд 5 цэн олгодог байжээ. Журганы тушааж өгсөн 40 хоногийн 303 лан 2 цэн мөнгийг Бадамдорж энэ удаад да лам нар яваагүй учир тэдний мөнгийг өөрийг нь дагалдан явсан хүн бүрд зохихийг үзэж тохируулан олгоход: шанзудбад 75 лан 8 цэн, 15 да ламын мөнгийг бараа болсон эмч, бичээч, хаалгач, аягач 3, хиа 1, жич зайсан Цэвэгням, түшмэл зайсан Лувсанцэрэн, хаалгач, хөтөл нарт, ачигч зэрэг 15 хүнд зохихыг үзэн тус тус хуваан өгчээ.

Сүмд хурал хурах үед эгнээний эхэнд шанзудба Бадамдорж, түүний дараа Өвөр Монголын хутагтууд дараалан заларч байжээ. Манжийн эзэн хаанд бараалхасны дараа шагнал буулгахад шанзудба Бадамдоржид шар магнаг торго 1 бүхэл, шар торго 1 бүхлийг хүртээжээ.

Шинэлэхийн жасааны үед хэд хэдэн сүмд ном уншиж, цам, сор залж байжээ. Зарим сүмийн хурлын үеэр мөн бэлэг сэлт өгч байх юм. Тухайлбал, Бо хуян тян сүмд Жигжид, Чойжон хурсны дараа ноёнтонд их бага хавтага 10, бага найман тахил 8 хэсэг мөн ембүү хоёрыг шагнаснаас тахил, ембүү бүхий хавтагийг хүрэмний хоёрдугаар товчноосоо зүүжээ. Мөн тахилга үйлдэж тахилгын шагнал буулгахад, түүнд шаазан хундага нэг, шаазан таваг нэг, бага цэнхэр шил сав нэг, утсан осоортой хутга нэг, тугалган савтай цай хоёрыг шагнажээ.

¹² Монголчуудтай худалдаа арилжаа хийхээр гэрээ байгуулсан хятад худалдаачдыг тийнхүү түнш хэмээн нэрлэдэг байв

¹³ Өвөр Монголын зургаан чуулган

Гучин гуравдугаар оны (1907) цагаан сарын шинийн хоёронд Бадамдорж Бээжингийн засаг лам гэх мэт томоохон лам нарт хадаг барьжээ. Бо хуян тян сүм сар шинийн бэлэг болгож Бадамдоржид хавтага нэг хос, хэт нэг, хүрэн шил сав нэг, гал өнгөтэй торго нэг бүхэл, хуа панс нэг бүхэл, төвд хүрэн цэсэм нэг бүхэл, булганы арьс 12, хэрэмний арьс 24-ийг шагнажээ. Ингээд тэд Бээжинд 1 сар гаруй хоноод нутаг буцжээ. Буцах замдаа мөн 32 өдөр явж, Маймаа хотын баруун этгээд Туул голын хөвөөнд ирэхэд нь Их Хүрээнээс тэднийг угтан 3 хүн очиж, тэд тэндээ хоноглоод маргаашийн могой цагт Хүрээнд морилж, Сэцэн хан Түшээт хан хоёр аймгаас байгуулсан асарт цай барьж, басхүү дундаасаа байгуулсан асарт ихэс лугаа учирч, цай барьж ёслон, олон хуврагийн амгалангийн хадгийг солиод Шаравпэлжээлин сүмд бараалхаж, Богдод мөргөөд дараа Хүрээний хоёр Амбанд бас Хүрээ ордонд морилж Очирдарь шүтээнд мөргөж мөн өдрийн бичин цагт тамгаа хүлээн авч, бичиг тамгалаад яаманд морилж, Шүтээнд мөргөж ёслоод тамганы өрөөнд морилж, ёслоод зүүн өргөөндөө морилжээ.

Ингээд шанзудбагийн аян замын өдрийн тэмдэглэлийг түүх сонирхогч нартаа зориулан бид монгол бичгээс кирилл үсэгнээ хөрвүүлэн нийтлүүлэн танилцуулж байна. Уг тэмдэглэлээс судлаач нар хэрэгцээтэй мэдээллээ авах боломж бас ч буй.

Бадаргуулт төрийн гучин хоёрдугаар онд Эрдэнэ шанзудба ноёнтан жасаалхаар морилохуй дор буудаллаж хоносон газрын нэр зэргийн данс¹⁴

Бадаргуулт төрийн гучин хоёрдугаар он буюу Европ тооллын 1906 онд Эрдэнэ шанзудба ноёнтон Бадамдорж Манж Чин улсын нийслэл хот Бээжинд Шинэлэхүйн жасаанд морилохуй дор арван сарын арван нэгэнд Богдод мөргөж, Их цай хүртээд арван хоёрны морин цагт, Их Хүрээнээс морилохуй дор яамны үүдэнд нь сангийн олон албаны хүмүүн нар яамны үүдэнд ёслон зогсов. Тэндээс ордонд морилж, Очирдарь шүтээнд өргөж ёслон, тамгыг хамааруулж Шаравпэлжээлин сүм¹⁵ дор дээр бараалхав.

Дараагаар цайны асар дор их цай хүртэж, олон хувраг амгалангийн хадаг сольж, ихэс лугаа ёсолж мөн Эрдэнэсэцэн ноёнд, Вангай хоёр аймгаас байгуулсан асар дор цай барьж ёслоод, Маймаа хотын баруун этгээд Туул голын хөвөөнд хонов. Энэ өдөр сангаас дөрвөн хүн манав.

13-нд Сайд бэйсийн нутаг Баянгийн хүзүүвчид хонов. Хаалгачийн хөтөл Чүлтэм, Лувсанцэрэнгийн хүү лам Пунцаг нар манав.

14-нд Мөн нутгийн Бор үзүүрийн талд хонов. Эмч Хөтөл Шагдар бараа бологч Нацагдоогийн хүү Дэмбэрэл нар манав.

15-нд Мөн нутгийн гүн худгийн талд хонов. Зайсан хөтөл Ринчен, бараа бологч Нацагдоогийн хүү Дондог нар манав.

16-нд Сэцэн вангийн нутгийн Дээрэхидийн талд хонов. Ачигч Наран, Лувсанцэрэнгийн хүү Хар Пунцаг нар манав.

17-нд мөн нутгийн уулзварт хонов. Бичээчийн хөтөл Лувсанцэрэн, аягачны хөтөл Балжинням нар манав. Тэмээ услав

¹⁴ УТА Ф-М85, Д1, хн 1259

¹⁵ VIII Богд Жавдандамба хутагтад зориулж “Билгийг хөгжүүлэн бадруулагч хийд” хэмээх Ногоон ордны цогцолборыг 1893-1903 онд барьсан. Уг хийдийн түвд нэр нь Шаравпэлжээлин.

18-нд Мөн нутгийн Хавтгайн талд хонов. Хаалгачийн хөтөл Чүлтэм, Лувсанцэрэнгийн хүү лам Пунцаг нар манав.

19-нд мөн нутгийн Алтганы хойд энгэрт хонов. Лувсанцэрэнгийн хүү Бор, Нацагдоогийн хүү Дэмбэрэл нар манав.

20-нд Хэбэй мэргэн вангийн нутгийн Дайн тавгийн талд хонов. Эмчийн хөтөл Шагдар, Нацагдоогийн хүү Пунцаг нар манав.

21-нд мөн нутгийн Муруй-улаан худагт хонов. Зайсангийн хөтөл Ринчен, Лувсанцэрэнгийн хүү хар Пунцаг нар манав. Тэмээ услав.

22-нд мөн нутгийн их үүднээ Хойд ширээнд хонов. Бичээчийн хөтөл Лувсанцэрэн, аягачны хөтөл Балжинням нар манав.

23-нд мөн нутаг хоорондын Хөөвөрт хонов. Ачигч Наран, аягачийн хөтөл Балжинням нар хонов.

24-нд мөн нутгийн Хөтөл усад хонов. Эмчийн хөтөл Шагдар, хаалгачийн хөтөл Чүлтэм нар манав. Тэмээ услав.

25-нд Баруун Сөнөдийн нутаг¹⁶, Хултын ширээгийн хойд ирмэгт хонов. Зайсангийн хөтөл Ринчен, Нацагдоогийн хүү Дондог нар манав.

26-нд мөн нутгийн Гүнгийн ширээнд хонов. Нацагдоогийн хүү хар Пунцаг, Лувсанцэрэнгийн хүү Бор нар манав.

27-нд Хоолтын сүмийн дэргэд хонов. Бичээчийн хөтөл Лувсанцэрэн, аягач Наран нар манав.

28-нд мөн нутгийн Бага бүтэмжийн ард хонов. Хаалгачийн хөтөл Чүлтэм, Лувсанцэрэнгийн хүү лам Пунцаг нар манав.

29-нд Цахар нутгийн Шарвингийн өвөрт хонов. Эмчийн хөтөл Шагдар, бараа бологч Дондог, Лувсанцэрэнгийн хүү Бор нар манав.

30-нд мөн нутгийн Чонын голын урд, ард хонов. Зайсангийн хөтөл Ринчен, бичээч Лувсанцэрэн, ачигч Наран нар манав.

11 сарын шинийн 1-нд мөн нутгийн Майнтийн өвөрт хонов. Хаалгачийн хөтөл Чүлтэм, Нацагдоогийн хүү Дондог, Лувсанцэрэнгийн хүү Пунцаг нар манав.

2-нд Тагаангууд хонов. Хаван Гиваанпэлийнд тэргээ тавив. Эмчийн хөтөл Шагдар, бараа бологч Нацагдоогийн хүү Дэмбэрэл, хаалгач Лувсанцэрэнгийн хүү Бор нар манав. Энд Жанжакоү¹⁷-гийн иргэн, Бээжингийн түнш иргэн, Баянсүмийн иргэн нар эрмэ жууз угтав.

3-нд Жанжакоүгийн түнш “малгай” Эрдэнийн хуучин пүүсэнд буув.

4-нд өнжив.

5-нд 60 газар¹⁸ явж Баянсүмийн түнш Баянмөнхийнд хонов.

6-нд 30 газар явж Хар ямаатын дэнд үдлээд, 30 газар явж Жими ша-д хонов.

7-нд 40 газар явж Саа-чинд үдлээд, 50 газар явж Хойлонд хонов.

8-нд 50 газар явж ар Чидео-д үдлээд 45 газар явж өвөр Нанкуд хонов.

9-нд 43 газар явж Ша-кэд үдлээд 50 газар явж Халх куанд¹⁹ түнш

Энхжаргалын пүүсэнд буув.

10, 11-нд энгийн өнжив.

¹⁶ Өвөр Монголын нутагт орж ирэв

¹⁷ Жанжакоү- Чуулалт хаалга.

¹⁸ Газар-уртын хэмжээ, 360 алд буюу 576 метр

¹⁹ Куан- хүрээ гэсэн үг

12-нд Чиан мэнд морилов.

13,14-нд энгийн өнжив.

15-нд Журганд албаны бичгийг өргөв.

16,17,18-нд энгийн өнжив.

19-нд Чиа мэнд морилов.

20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29-нд энгийн өнжив.

Энэ бага сар. 12 сарын шинийн нэгэн, хоёронд энгийн өнжив.

3-ны 20 цагт Монгол Журганаас ноёнтон ба бусад жасааны Дотоод чуулган, Хөх хот зэрэг газрын хутагт Номун хан, хувилгаан лам нар бие үзээрээ заларсанд, ноёнтон шулуун шар дээл, булган хүрэм, эрх, сүйхтэй морилж, шобан²⁰ нарын суудаг байшинд түр хүлээж байтал ноёнтоноос эхлэн нижгээдээр бараалхуулсанд: Журганы ноёдын амрыг эрж ёслоод, Халх куанд буцаж морилов.

Энэ өдөр барилгын²¹ Аюуш бурхан 1, Цагаан нанжид хадаг 1, булга нэг ес, төвд чэсэм²² хоёр ес, морь хоёр ес: бурхан, хадаг, чэсэмийг Журганы ван шобанд үзүүлэн тушааж, морьдыг басхүү арван тавыг Да ламын барилгын нэгжээд морьны хамт Монгол Журганы ноёдод үзүүлээд, Халх куанд тэжээж хонов.

4-нд дотор морилж Мандул хутагтын санд буув. Морьдыг барилгын дотор оруулж, ойр бүхий нэгэн айлын хашаанд тэжээлгэж хонов.

5-ны туулай цагийн эхний мөчид ноёнтон шулуун шар дээл, цагаан үстэй урт шар хүрэм, сүйж²³, морилж, дээдийн амгаланг эрж, бурхан, хадаг, булга, чэсэм, морьдыг барьсанд цөм тоогоор тогтов. Энэ өдөр ламын тамга хамаарсан засаг лам Лйү, нөгөө 3 засаг лам, 2 Еүй чин гэсхүй-гийнд морилов.

6-нд Бээжингийн зүүн этгээд худалдааны газар морилов.

7-нд үхэр цагийн эхний мөчид ноёнтон шулуун шар дээл, булган хүрэм, эрх сүйжин молцоготой²⁴ морилж, Боо хуан тян сүмд итгэл дарь эх хурахуй дор, зүүн талын эхний ламын тамга хамаарсан засаг лам Лйү тэргүүлэн, Зы ху хамба да лам, Еүй чин умзад нар сууснаас гадна бусад лам нар уг Журганаас жагсааж тогтоосон ёсоор баруун талын эхэнд ноёнтон, дараа нь Хөх хотны Эрдэнэ мэргэн бандида Дүйнхүр хутгат, Хөх нуурын Цагаан номун хан, Авга нар Эрдэнэ мэргэн, Далайдын хувилгаан, Нарт сүмийн хувилгаан Хамба Эрдэнэ Номун хан, Цахарын мэргэн бандида, Эрх цоржийн хувилгаан нар дараалан суув. Туулай цагийн дунд мөчид эзэн гэгээн²⁵ заларч хүж барьж, мөргөсөн дор бүгд лам нар нударга буулгаж өөр өөрийн дэвсгэр дээрээ сөгдөж байв.

8-ны барс цагийн дунд мөчид ноёнтон магнаг дээл, булган хүрэм, эрх сүйжин молцоготой морилж мөн Бо хуан тян сүмд итгэл Дарь эх мөн Чадав хурав.

Энэ өдөр сор залахын дэг дэглэв. Эзэн гэгээн заларсангүй.

9-ны барс цагийн дунд мөчид ноёнтон магнаг дээл, булган хүрэм, эрх сүйжин молцоготой морилж, Бо хуан тян сүмд Чойжин мөн Дүгжүв, Жүгдэртүгчин хураад гадаалж, мөнхүү сүмийн үүдэнд байгуулсан шар асарын

²⁰ Шобан- бага туслагч гэсэн үг.

²¹ Өргөн барих зүйлийг хэлж буй

²² Чэсэм- бөс.

²³ Сүйж –усан болор, Шанзудба сүйжин эрихтэй явжээ.

²⁴ Молцог-унжуулсан чимэг

²⁵ Манж Чин улсын эзэн хаан Цзайтянь (1871-1908). Оны цол Гуансюй, монголоор Бадаргуулт төр

зүүн өмнө, өөр өөрийн дэвсгэр дээрээ сөгдөн байтал эзэн гэгээн заларч, сүмийн үүдэнд хүж барьж мөргөөд шар асарт сууж залармагц, засаг лам, Ейү-чэн гэсгүй, умзад нар асарын үүдэнд босоо зогсож, угаах ном, Жүгдэр уншисны дараа, Чойжилын Түгжү Жүгдэртугчин залаад асарын зүүн үүдэнд Даш ном уншиж төгсөнгүүт ламын тамга хамаарсан засаг лам Лйү ноёнтон Хөх хотын эрдэнэ мэргэн Дүйнхүр бандида, Хөх нуурын цагаан Номун хан, Бээжингийн засаг лам болон Бо нарын 5 хүн, эзэн гэгээнээ хадаг өргөсөнд тус тусын хүзүүн дээгүүр урт цагаан хадаг шагнасанд босч хойш ухарсаар өөр өөрийн дэвсгэр дээрээ суув. Дараагаар эзэн гэгээн сүү өргөж зооглох сацуу, жасааны лам нар дэвсгэр дээрээ сөгдөж мөргөв. Мөн лам нарт нижгээд аяга сүү булгасныг хүртээд, шагнасан хадгийг буулгаж авав. Эзэн гэгээн буцаж залархуй дор жасааны лам нар урдын ёсоор өөр өөрийн дэвсгэр дээрээ сөгдөж байв. Дараа нь гадаалж түр хүлээж байтал ноёд түшмэд ирж шагнал буулгахад, ноёнтонд шар магнаг 1 бүхэл, шар торгыг 1 бүхлийг шагнав.

10-ны барс цагийн эцсийн мөчид ноёнтон магнаг дээл, булган хүрэм, эрих сүйжин молцогтой морилж, Бо хуан тян-д Намсрай хураад, гадаалсаны дараа сүмийн үүдэнд Намсрайн цам бүжиглэв. Энэ өдөр эзэн гэгээн заларсангүй.

11-ны луу цагийн эхний мөчид ноёнтон шулуун шар дээл, цагаан үстэй урт шар хүрэм, сүйжин нарийн орхимжтой морилж бусад лам нарын хамт Бо хуан тян сүмийн үүдэнд урдын магнаг торго шагнасан тухай хишигт малгай авч ламын ёсоор гурвантаа мөргөөд, Сэцэн чин вангийн дор морилоод Халх куанд буцаж морилов. Энэ 8 өдөр зайсан Цэвэгням, бичээч Мөрдондов, хаалгач Дондов, аягач 2, хиа нэг бараа бололцов.

12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21 энгийн өнжив.

22-нд дотор морилж, Мандул хутагтын санд буув.

23-ны туулай цагийн дунд мөчид ноёнтон шулуун шар дээл, булган хүрэм, эрих сүйжин молцогтой морилж Бо хуан тян сүмийн үүдэнд ноёд, лам нарт галын тахилганы шагнал буулгахад ноёнтонд шаазан хундага 1, шаазан таваг нэг, бага цэнхэр шил сав 1, утсан оосортой хутга 1, тугалган савтай цай 2-ыг шагнав. Энэ өдөр Халх куанд буцаж морилов.

24-нд энгийн өнжив.

25-нд дотор морилж, Мандул хутагтын санд буув.

26-ны туулай цагийн эхний мөчид ноёнтон шулуун шар дээл, булган хүрэм, эрих сүйжин молцогтой морилж Бо хуан тян сүмд Их Манал хурав.

27-ны барс цагийн дунд мөчид ноёнтон магнаг дээл, булган хүрэм, эрих сүйжин молцогтой морилж Бо хуан тянд Итгэл, Аюуш, Сэдэд, Юм хураад гадаалсаны дараа, сүмийн үүдэнд цамын дэг дэглэв.

28-ны барс цагийн тэргүүн мөчид ноёнтон магнаг дээл, булган хүрэм, эрих сүйжин молцогтой морилж Бо хуан тян сүмд Жигжид, Чойжон хураад, гадаалсаны дараа шан буулгахад ноёнтонд их бага хавтага 10, бага мөнгөн найман тахил 8 хэсэг мөн ембүү хоёрыг шагнаснаас тахил, ембүү бүхий хавтагийг хүрэмны 2 дугаар товчноос зүүж мөн сүмийн үүдэнд байгуулсан шар асарын зүүн өмнө морилов сууж байтал, эзэн гэгээн залран ирмэгц жасааныхан өөр өөрийн дэвсгэр дээрээ нударга буулган сөгдөөд, эзэн гэгээн залран суусны

дараа цам бүжиглэж, сур залж өнгөрмөгц засаг лам Ейүчин умзад нар шар асарын өмнө босоо зогсож, ном уншиж төгсөнгүүт, ноёнтон Хөх хотын Эрдэнэ мэргэн Дойнхор бандида хутагт, Хөх нуурын Цагаан номун хан, Авга нарын Эрдэнэ мэргэн, Жалайдын хувилгаан, Бээжингийн засаг лам Хүн, Жучи нарын 6 хүн эзэн гэгээнээ хадаг өргөсөнд тус тусын хүзүүн дээр урт цагаан хадаг шагнасанд гэдэргээ ухарсаар суудалдаа суув. Эзэн гэгээн сүү өргөөд зооглох сацуу жасааны лам нар өөр өөрийн дэвсгэр дээрээ мөргөв. Мөн лам нарт нижгээд аяга сүү буулгасаныг хүртээд, хадгийг буулгаж авав. Эзэн гэгээн буцаж залрахад мөн урьдын ёсоор өөр өөрийн дэвсгэр дээрээ сөгдөж байв. Энэ өдөр Халх куанд буцаж морилов. Зайсан Цэвэгням, бичээч Мөрдондов, хаалгач Дондог, аягач 2, хиа 1 бараа болж суув.

29, 30-нд энгийн өнжив. Гучингуравдугаар оны цагаан сарын шинийн нэгэнд энгийн өнжив.

2-нд ноёнтон магнаг дээл, булган хүрэм, эрих сүйжин молцоготой морилж Үн хэ гүн сүмийн Сэдэдэд мөргөж, ламын тамга хамаарсан засаг лам Лйү лугаа учраад Гүн жүнтан, ван Цэрэнбавай, чин ван, Бээжингийн засаг лам Бо нар гаднаас амар эрүүлж, хадаг бариулав.

3, 4, 5, 6, 7, 8, 9-нд энгийн өнжив.

10-ны туулай цагийн дунд мөчид ноёнтон магнаг дээл, булган хүрэм, эрих сүйжин молцоготой морилж Боо хуан тян сүмийн газарт энгийн шан өгөхөд ноёнтонд хавтга нэг дүй²⁶, хэт 1, хүрэн шил сав 1, гал өнгөтэй торго 1 бүхэл, хуа панс 1 бүхэл, төвд хүрэн цэсэм нэг бүхэл, булга 12, хэрэм 24-г шагнав.

11, 12, 13, 14, 15-нд энгийн өнжив.

16-нд Чиан мэнд морилов.

17, 18-нд энгийн өнжив.

19-ны туулай цагийн дунд мөчид ноёнтон шулуун шар дээл, булган хүрэм, эрих сүйжин молцоготой морилж, дотоод хотын баруун хаалгаар Чинвангүн хэмээх газар морилж, дээдийн амгаланг айлтгав. Энэ өдөр хаалгач Дондог, түншийн их бичээч Баянсан нарыг хадаг, жимстэй явуулж, Гүн жунтан, Сэцэн чин ван, Цэрэнбавай нарын амрыг эрүүлэв.

20-ны туулай цагт Халх куанаас 50 газар явж Ша кэд үдлээд 43 газар явж, өвөр Нанку-д хонов.

21-нд 45 газар явж Чидо-од үдлээд, 50 газар явж Хуйлан-д хонов.

22-нд 50 газар явж, Са чин-д үдлээд, 40 газар явж Жиме ша-д хонов.

23-нд 30 газар явж Хар ямаатад үдлээд, 30 газар явж Баянсүмийн түнш Баянмөнхийнд хонов.

24-нд 60 газар явж Жан жа кyo хаалганы гадна, түнш “малгай” Эрдэнийн шинэ пүүсэнд буув.

25, 26, 27-нд энгийн өнжив.

28-нд Жан жа коy-аас гарч 60 газар явж Тангү-д хонов. Аягачингийн хөтөл Балжинням бараа бологч нарын жинчны хүү Дондог, хаалгач хар Пунцаг нар манав.

²⁶ Дүй-хос гэсэн үг

29-нд Цахарын нутаг Майнтад хонов. Зайсангийн хөтөл Ринчен, бичээч Лувсаанцэрэн, ачигч Наран нар манав.

Энэ сар бага. 2 сарын шинийн нэгэнд мөн нутгийн Чоно голын урд, ард хонов. Эмчийн хөтөл Шагдар, хаалгачийн хөтөл Чүлтэм, Лувсанцэрэнгийн хүү Борөвгөн нар манав.

2-нд мөн нутгийн Богдын голд хонов. Тэмээ услав. Бараа бологч нарын хүү Дондог, хаалгач хар Пунцаг нар манав.

3-нд Сөнөд нутгийн Тавын шандад хонов. Аягачны хөтөл Балжинням Лувсанцэрэнгийн хүү лам Пунцаг нар манав.

4-нд мөн нутгийн Санбулаг-т хонов. Зайсангийн хөтөл Ринчен, бичээч Лувсанцэрэн нар манав.

5-нд мөн нутгийн Цагаанчулуутад хонов. Хаалгачийн хөтөл Чүлтэм, ачигч лам Наран нар манав.

6-нд өнжив. Тэмээ услав. Эмчийн хөтөл Шагдар, Лувсанцэрэнгийн хүү Борөвгөн нар манав.

7-нд мөн нутгийн Давсаны өмнөх ирмэгт хонов. Бараа бологч жинчны хүү Дондог, хаалгачны хүү хар Пунцаг нар манав.

8-нд Хэбэй мэргэн вангийн хошууны нутаг Чулуун дүүрэг-д хонов. Аягачингийн хөтөл Балжинням, Лувсанцэрэнгийн жинчны хүү лам Пунцаг нар хонов.

9-нд мөн нутгийн Завгийн өвөрт хонов. Зайсангийн хөтөл Ринчен, бичээчийн хөтөл Лувсанцэрэн нар манав.

10-нд мөн нутгийн Санжаагийнд хонов. Хаалгачийн хөтөл Чүлтэм, ачигч лам Наран нар манав.

11-нд мөн нутгийн Муруй улаан худаг-т хонов. Тэмээ услав. Эмчийн хөтөл Шагдар, Лувсанцэрэнгийн хүү Борөвгөн нар манав.

12-нд мөн нутгийн Дайн тавгийн талд хонов. Бараа бологч жинчны хүү Дондог, хаалгачийн хүү хар Пунцаг нар манав.

13-нд Сэцэн вангийн нутгийн Алтгананы хойд энгэрт хонов. Аягачны хөтөл Балжинням, Лувсанцэрэнгийн хүү лам Пунцаг нар хонов.

14-нд мөн нутгийн Хадмал-д хонов. Зайсан хөтөл Ринчен, бичээчийн хөтөл Лувсанцэрэн нар манав.

15-нд мөн нутгийн Бэлхэд хонов. Энэ өдөр ноёнтон Сэцэн вангийнд морилов. Эмчийн хөтөл Шагдар, Лувсанцэрэнгийн хүү Борөвгөн нар манав.

16-нд мөн нутгийн Сансарын хөтөлд хонов. Хаалгачийн хөтөл Чүлтэм, ачигч Наран нар манав.

17-нд мөн нутгийн Тэргэтийн талд хонов. Бараа бологчийн хүү Дондог, хаалгач хүү хар Пунцаг нар манав.

18-нд Сайд бээсийн нутгийн Өгөөмөрт хонов. Тэмээ услав. Аягачины хөтөл Балжинням, Лувсанцэрэнгийн хүү лам Пунцаг нар манав.

19-нд мөн нутгийн Шандын нуруунд хонов. Ачигч Наран, Лувсанцэрэнгийн хүү Борөвгөн, хар Пунцаг нар хонов.

20-нд мөн нутгийн Борүзүүрийн талд хонов. Бичээчийн хөтөл Лувсанцэрэн, хаалгачийн хөтөл Чүлтэм, бараа бологч хүү Дондог, хаалгачийн лам Пунцаг нар хонов.

21-нд мөн нутгийн Цагаан тэмээтийн хошуунд хонов. Эмчийн хөтөл Шагдар, аягачийн хөтөл Балжинням, Лувсанцэрэнгийн хүү Борөвгөн, хар Пунцаг нар манав.

22-нд мөн нутгийн Баянгийн хүзүүвчний ард хонов. Зайсангийн хөтөл Ринчен, ачигч Наран, бараа бологчийн хүү Дондог, хаалгачийн хүү лам Пунцаг нар хонов.

23-нд өнжив. Бичээчийн хөтөл Лувсанцэрэн, хаалгачийн хөтөл Чүлтэм, Лувсанцэрэнгийн хүү хар Пунцаг, Борөвгөн нар манав.

24-нд Маймаа хотын баруун этгээдэх Туул голд хонов. Бараа бологчын жинчны хүү Дондог, хаалгачийн лам Пунцаг, Сангийн хүү Намсрай, Доной нар манав.

25-нд могой цагт морилж, 2 аймгаас байгуулсан асарт цай барьж, басхүү дундаасаа байгуулсан асарт ихэс лугаа учирч, цай барьж ёслон, олон хуврагийн амгалангийн хадгийг солиод Шаравпэлжээлин сүмд бараалхаж, Богдод мөргөөд, түүгээр хоёр Амбанд морилоод Хүрээ ордонд морилж Очирдарь шүтээнд мөргөж мөн өдрийн бичин цагт тамгаа хүлээн авч, бичиг тамгалаад яаманд морилж, Шүтээнд мөргөж ёслоод тамганы өрөөнд морилж, ёслоод зүүн өргөөнд морилов.

Хүнс буусан нэгэн зүйл

32 оны 12 сарын 28-нд хүнс буухын зар түншийнд ирмэгц аягач Цэндийг түншийн 1 бичээчийн хамт Монгол Журганы яаманд очиж бараалхсанд ноёнтон ба 15 да ламын хүнсний хамт хэмээн тушааж өгсөнийг хүлээн авч авчирсаныг үзвээс бүгд 153 лан 2 цэн бөгөөд үүнд ноёнтоны хүнсний мөнгө өдөр бүр 2 лан 5 цэн, бүгд: 20 хоногт 50 лан байваас зохих ба 15 да ламын хүнсэнд өдөр бүр хүн тутамд 5 цэн, бүгд 20 хоногт 150 лан байваас зохих боловч Журганы тушааж өгсөн 153 лан 2 цэнийг хүн бүрд зохихыг үзэж тохируулан ноёнтонд 35 лан 3 цэн. Бас 15 да ламын хүнсний мөнгийг бараа болсон эмч, бичээч, хаалгач, аягач 3, хиа 1, жич Зайсан Цэвэгням нарт 96 лан 9 цэн бас түшмэл зайсан Лувсанцэрэн, хаалгач Лувсанцэрэн нарт 12 лан, хөтөл, ачигч 6 хүнд 6 лан хүртээжүхэй.

Дараагийн 20 хоногийн хүнс буухын урьд, хойш буцсан учирт Бээжин түнш лугаа зөвлөлдөн хэлэлцэж урьдчилан авахад бүгд авсан 150 лангаас ноёнтонд 40 лан 5 цэн; эмч, бичээч, хаалгач, аягач 3, хиа 1, жич Зайсан Цэвэгням, хаалгач Лувсанцэрэн эдгээр 9 хүнд 103 лан 5 цэн, ачигч, хөтөл 6 хүнд 6 ланг тус тус хуваан хүртээв.

Abstract: *This article describes a visit of the Mongolian noble in time of the Manchu Qing dynasty to Beijing to attend a New year Ceremony. The note on the journey and participation into new year gathering in Beijing left by Erdene Shanzudba Badamdorji (1906) was found in the archives and has been translated into modern Mongolian.*